



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 472

Улаанбаатар хот

Хөрөнгө худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголросцветмет” ХХК-ийн /хуучин нэрээр/ Зөвлөлийн 49 дүгээр хурлын протоколын 12.1-д заасны дагуу “Ай Ди Си Реэл Стэйт” ХХК-тай байгуулсан MR-2017-03-61 тоот “Хамтран ажиллах тухай” гэрээний дагуу хүлээн авсан 348.28 м.кв талбай бүхий 7 ширхэг орон сууц, 2 ширхэг автомашины зогсоолыг ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор хавсралтад заасны дагуу худалдан борлуулахыг зөвшөөрсүгэй.

2. “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Мөнхбатад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу тус үйлдвэрийн газрын ажиллагсадтай гэрээ байгуулан худалдах ажлыг зохион байгуулах;

2.2. Орон сууц худалдсанаас олох орлогыг зохих журмын дагуу үйлдвэрийн газрын дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягтыг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2020 оны 10 дугаар сарын...-ны өдрийн
 472 дугаар тогтоолын хавсралт

**“МОНГОЛПРОСЦВЕТМЕТ” ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
 ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

№	Орон сууцны байрны байршил	Байрны давхар, хаалганы дугаар	Байрны талбай /м.кв/	Өрөөний тоо	Худалдан борлуулах доод үнэ /м.кв/
Орон сууц					
1	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 22 дугаар хороо, Дандарбаатарын гудамж, "Тэлмү апартамент" хотхон №29-р байр	8 давхар, №101	51.96	2	1 м.кв 1,350,000.00 (нэг сая гурван зуун тавин мянга)
2		4 давхар, №12	51.96	2	
3		3 давхар, №63	51.96	2	
4		3 давхар, №62	51.96	2	
5		3 давхар, №02	51.96	2	
6		3 давхар, №06	51.96	2	
7		10 давхар, №114	36.52	1	
Авто зогсоол					
1	Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 22 дугаар хороо, Дандарбаатарын гудамж, "Тэлмү апартамент" хотхон №29-р байр	Зоорины давхар, №09	18		20,000,000.00 (хорин сая)
2		Зоорины давхар, №18	18		20,000,000.00 (хорин сая)